



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ЭРЭЛТИЙН СУДАЛГАА 2024

Захиалагч: Санхүүгийн зохицуулах хороо
Гүйцэтгэсэн: “Эн Ар Си Си” ХХК

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ЭРЭЛТИЙН СУДАЛГАА

“Эн Ар Си Си” ХХК

Хураангуй: Олон улсад санхүүгийн хүртээмжийг нийлүүлэлт тал буюу зохицуулалттай санхүүгийн үйлчилгээний захиргааны мэдээлэлд үндэслэн хэмжих нь хялбар бөгөөд түгээмэл байдаг. Нөгөөтгээгүүр нийлүүлэлт талын үзүүлэлтүүд нь бага орлоготой хүмүүс болон жижиг аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хүртээмжийг нарийн хэмжиж чаддаггүй байна. Санхүүгийн хүртээмжийн эрэлт талын цогц үзүүлэлтүүд манай улсад нэлээд хомс байна.

Эн Ар Си Си судалгааны компани Монгол Улсын санхүүгийн хүртээмжийн эрэлтийн үзүүлэлтүүдийг хэмжих зорилгоор 2024 оны 10 сард Улаанбаатар болон 21 аймгийн санамсаргүй сонгогдсон иргэдээс асуумж судалгаагаар мэдээлэл цуглуулж, шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна. Судалгааны үр дүнд манай улсад банкнаас бусад санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт, хүртээмж банктай харьцуулахад бага гэсэн үр дүн гарлаа. Ялангуяа, хөрөнгийн зах зээл болон хадгаламж, зээлийн хоршооны үйлчилгээнд хамрагдалт бусад санхүүгийн үйлчилгээтэй харьцуулахад эрс бага байна.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн үзүүлэлтүүд болон санхүүгийн боловсрол хүн амын бүлгээр ялгаатай байна. Орлого багатай эсвэл ажилгүй иргэдийн санхүүгийн хүртээмж муу байгаа бол эмэгтэйчүүдийн болон орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсрол доогуур байна.

JEL ангилал: D14, G22, G23, G24, P36, E66

Түлхүүр үг: Санхүүгийн хүртээмж, хүртээмжийн эрэлтийн үзүүлэлтүүд, санхүүгийн боловсрол, банкнаас бусад санхүүгийн байгууллагууд

АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	3
1. ОРШИЛ	4
2. САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ЭРЭЛТИЙН СУДАЛГАА	5
2.1. Санхүүгийн хүртээмжийг хэмжих нь.....	5
2.2. Судалгааны аргачлал	6
2.3. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж.....	8
2.3.1. ББСБ болон ломбардын үйлчилгээ	12
2.3.2. Зээлийн үйлчилгээ	14
2.3.3. Даатгалын үйлчилгээ	15
2.3.4. Дижитал санхүүгийн үйлчилгээ	17
2.4. Санхүүгийн үйлчилгээг авах сонирхол, итгэх итгэл	17
2.5. Санхүүгийн үйлчилгээний чанар	21
2.6. Санхүүгийн боловсрол.....	23
3. ДҮГНЭЛТ.....	26
ЗӨВЛӨМЖ.....	28
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ.....	28

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Бүсийн тархалт.....	7
Зураг 2. ББСБ, ломбардын үйлчилгээний хүртээмж, нийгэм эдийн засгийн шинж чанараар	12
Зураг 3. ББСБ, ломбардын үйлчилгээний хэрэглээ, ажил эрхлэлт, боловсрол, орлогын түвшнээр	14
Зураг 4. Сайн дурын даатгалд хамрагдалт, нийгэм, эдийн засгийн шинж чанараар	16
Зураг 5. Санхүүгийн үйлчилгээнд итгэх итгэл нийгэм эдийн засгийн шинж чанараар	21
Зураг 6. Санхүүгийн байгууллагууд бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ талаар тодорхой, ойлгомжтой мэдээлэл өгсөн байдал.....	22
Зураг 7. Санхүүгийн боловсролын асуултад зөв хариулсан хувь	24
Зураг 8. Санхүүгийн боловсрол, хүн амын бүлгээр	25
Зураг 9. Санхүүгийн боловсролын оноо ба төсөв хөтлөлт	26

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Түүврийн шинж чанар	8
Хүснэгт 2. Санхүүгийн хүртээмжийн эрэлтийн үзүүлэлтүүд	9
Хүснэгт 3. Санхүүгийн үйлчилгээ авдаг байдал нийгэм, эдийн засгийн шинж чанараар ялгаатай эсэх.....	11
Хүснэгт 4. Зээл авсан байдал нийгэм, эдийн засгийн шинж чанараар ялгаатай эсэх	15
Хүснэгт 5. Санхүүгийн үйлчилгээг авах сонирхол нийгэм, эдийн засгийн шинж чанараар ялгаатай эсэх.....	18
Хүснэгт 6. Санхүүгийн үйлчилгээнд итгэх итгэл нийгэм, эдийн засгийн шинж чанараар ялгаатай.....	19

1. ОРШИЛ

Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын санхүүгийн хүртээмжийн эрэлт талын үзүүлэлтүүдийг банк болон банкнаас бусад санхүүгийн үйлчилгээнүүд болох бичил санхүү, даатгал болон хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний хүрээнд цогц байдлаар хэмжихийг зорилоо. Олон улсад санхүүгийн хүртээмжийг нийлүүлэлт талын буюу зохицуулалттай санхүүгийн үйлчилгээний захиргааны мэдээлэлд үндэслэн хэмжих нь хялбар бөгөөд түгээмэл байдаг. Нөгөө талаас нийлүүлэлт талын мэдээлэл нь санхүүгийн хүртээмжийн олон талт байдлыг хэмжиж чадахгүй гэж судлаачид дүгнэдэг (Pesqué-Cela et al, 2021).

Санхүүгийн хүртээмжийн эрэлт талын цогц үзүүлэлтүүд манай улсад нэлээд хомс байна. Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) санхүүгийн хүртээмжийн эрэлтийн судалгааг анх 2018 онд (СЗХ, Эн Ар Си Си, 2018), 2021 онд Монголын банкны холбоо, Банк санхүүгийн академи банкны салбарын санхүүгийн хүртээмжийн судалгаа тус тус гүйцэтгэсэн. Эдгээр судалгаануудаас банкны үйлчилгээний хүртээмж өндөр гэж дүгнэжээ.

Монгол Улс Банканд данс эзэмшдэг үзүүлэлтээр санхүүгийн хүртээмж сайтай хэдий ч банкны зээлийн бүтээгдэхүүний хэрэглээгээр хөгжлийн хувьд ижил түвшний улсуудтай харьцуулахад доогуур байдаг болохыг санхүүгийн хүртээмжийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн үндэслэлд дурджээ. Учир нь манай улсад ихэвчлэн арилжааны банкны хадгаламж, зээлийн үйлчилгээгээр үйлчлүүлж хэвшсэн боловч банк бус санхүүгийн байгууллага (ББСБ), хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ), хөрөнгийн болон даатгалын зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ бага байна гэжээ..

Эн Ар Си Си судалгааны компани санхүүгийн хүртээмжийн эрэлтийн талын үзүүлэлтүүдийг хэмжих асуумжийг Олон улсын санхүүгийн нийгэмлэг (АФИ)-ээс гаргасан зааварчилгаа (АФИ, 2016) болон СЗХ-той зөвшилцөн боловсруулж, Улаанбаатар болон 21 аймгийн санамсаргүй сонгогдсон 500 иргэдээс уг асуумжийн дагуу мэдээллийг цуглууллаа.

Судалгааны үр дүнд манай улсад банкнаас бусад санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт, хүртээмж банктэй харьцуулахад илт бага байгаа үр дүн гарлаа. Ялангуяа, хөрөнгийн зах зээл болон ХЗХ-ны үйлчилгээнд хамрагдалт бусад санхүүгийн үйлчилгээтэй харьцуулахад эрс бага байна. Нөгөөтээгүүр судалгаанд хамрагдсан иргэд даатгал болон хөрөнгийн зах зээлийн талаар мэдлэг, мэдээлэл муу бөгөөд ойлгомжтой мэдээлэл авдаггүй гэж их хариулсан.

Үйлчилгээнд хамрагдахгүй байгаа иргэдийн дийлэнх нь хэрэгцээ шаардлагагүй учраас уг үйлчилгээг сонирхдоггүй гэж хариулж буй нь анхаарал татаж байна. Банкнаас бусад санхүүгийн үйлчилгээнд хамрагдаггүй иргэд санхүүгийн боловсролтой байхын хирээр санхүүгийн үйлчилгээг хэрэгцээ шаардлагагүй гэж үзэх нь илүү байна.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн үзүүлэлтүүд нь хүйс болон байршлаар ялгаа багатай байна. Харин орлого болон ажил эрхлэлтийн статусаас хамаарсан ялгаа ихтэй байна. Орлого багатай эсвэл ажилгүй иргэдийн санхүүгийн хүртээмж муу байна. Эсрэгээрээ

санхүүгийн боловсролын үзүүлэлт хүйс, байршлаас хамаарсан ялгаатай боловч орлогоор төдийлөн ялгаатай биш байна. Санхүүгийн үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний хувьд ил тод байдлын үзүүлэлт сайнгүй харин тав тухтай байдал, тэгш шударга үйлчилгээний үзүүлэлтүүд сайн гарчээ.

Тайлангийн хоёрдугаар бүлэгт санхүүгийн хүртээмжийн судлагдсан байдал, хүртээмжийг хэмжих арга зүй болон санхүүгийн хүртээмжийн эрэлтийн судалгааны үр дүнг танилцуулж, гуравдугаар бүлэгт судалгааны дүгнэлт, судалгаанаас гарч буй зөвлөмжийг орууллаа.

2. САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ЭРЭЛТИЙН СУДАЛГАА

Энэ бүлэгт санхүүгийн хүртээмжийн эрэлтийн үзүүлэлтүүдийг цогц байдлаар хэмжих үүднээс санамсаргүй сонгогдсон 500 иргэдээс авсан түүвэр судалгааны үр дүнг танилцуулна. Банк, ББСБ, даатгал, хөрөнгийн зах зээл болон ХЗХ-ны санхүүгийн үйлчилгээний хүртээмж, санхүүгийн үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд болон санхүүгийн боловсрол гэсэн олон талт үзүүлэлтүүдийг хэмжиж, шинжилгээ хийлээ.

2.1. Санхүүгийн хүртээмжийг хэмжих нь

Санхүүгийн хүртээмж нь бүх иргэн, бизнес эрхлэгчид хөрөнгө чинээ, компанийн хэмжээнээс үл хамааран хэрэгцээ, худалдан авах чадварт нь тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүртэх боломжтой эсэхийг харуулдаг үзүүлэлт юм. Хувь хүмүүс, өрхүүд, бизнес эрхлэгчдийн хуримтлал хийх, зээлэх, төлбөр тооцоо, шилжүүлэг хийх, болон эрсдэлээ удирдах үйл ажиллагаанд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зайлшгүй хэрэгцээтэй байдаг.

Санхүүгийн хүртээмжийг голдуу санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэдэг хүмүүс эсвэл аж ахуйн нэгжүүдийн эзлэх хувиар хэмждэг. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрэлцээ ба хэрэглээ нь санхүүгийн хүртээмжийн хоёр чухал хэмжээс бөгөөд санхүүгийн хүртээмж муу байх нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүрэлцээгүй гэсэн үг биш юм. Санхүүгийн хүртээмжид бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт, үнэ зэргээс гадна эрэлт чухал нөлөөтэй хүчин зүйл байдаг. Иймд санхүүгийн хүртээмж доогуур байгаа нь эрэлтийн хүчин зүйлсээс шалтгаалж байна уу эсвэл нийлүүлэлтийн хүчин зүйлсээс шалтгаалж байна уу гэдгийг тодорхойлох нь санхүүгийн хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөрт чухал ач холбогдолтой.

Олон улсад санхүүгийн хүртээмжийг маш идэвхтэй судалж, эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулахад эерэг нөлөөтэйг нотолсоор байна (Ozili, 2021), (Ozili et al., 2023). Duvendack, Mader (2020) нар санхүүгийн хүртээмжийн хөтөлбөрийн нөлөөний судлагдсан байдлын судалгаа буюу мета-анализ хийжээ. Тэд 32 судлагдсан байдлын судалгааны үр дүнг шинжилсэн бөгөөд санхүүгийн хүртээмжийн хөтөлбөр эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад ерөнхийдөө эерэг нөлөөтэй ч, нөлөөний хэмжээ нь соёл, орон нутаг, болон санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хөтөлбөрийн шинж чанараас ихээхэн хамааралтай гэж дүгнэжээ.

Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлтийн талаар мэдээ мэдээлэл харьцангуй элбэг байдаг. Учир нь бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлтийн талаарх мэдээлэл захиргааны мэдээллийн санд бүртгэл, татвар зэрэг олон сувгаар хуримтлагдаж байдаг. Тиймээс санхүүгийн хүртээмжийн судалгаануудад нийлүүлэлт талын тоон үзүүлэлтүүдийг түгээмэл ашигладаг.

Pesqué-Cela et al. (2021) нар санхүүгийн хүртээмжийн судалгаанууд нийлүүлэлт талыг хэмжихэд чиглэсэн хүртээмжийн тоон үзүүлэлтүүдийг илүүтэй ашиглаж байгаа нь санхүүгийн хүртээмжийн олон талт байдлыг хэмжиж чадахгүй байна хэмээн шүүмжилсэн байдаг. Ингэснээр бага орлоготой хүмүүс болон жижиг аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хүртээмжийг нарийн хэмжиж чаддаггүй байна.

Эрэлт талын үзүүлэлтүүд хэдий чухал ач холбогдолтой ч эрэлтийн талаарх мэдээлэл, тоон өгөгдөл ялангуяа хөгжиж буй орнуудад ховор хомс байна. Үүнийг шийдэхэд Дэлхийн банк нэгэн чухал алхам хийсэн нь Global Findex датабааз юм. Дэлхийн банк 2011 оноос Global Findex датабаазыг хөгжүүлснээр дэлхий даяар насанд хүрэгчид хадгаламж, зээл, төлбөр, эрсдэлээ хэрхэн удирдаж байгаа талаарх цогц мэдээллийн сан бий болсон (Demirgüç-Kunt & Klapper, 2012), (Demirgüç-Kunt et al., 2020).

Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийн эрэлт талын мэдээлэл манай улсад ч нэлээд хомс байдаг. СЗХ санхүүгийн хүртээмжийн эрэлтийн талын судалгааг анх 2018 онд хийсэн (СЗХ, Эн Ар Си Си, 2018). Уг судалгаанаас банкны үйлчилгээний хүртээмж өндөр бөгөөд хүйсийн ялгаа байхгүй гэж дүгнэжээ. 2021 онд Монголын банкны холбоо, Банк санхүүгийн академи банкны салбарын санхүүгийн хүртээмжийн судалгаа хийсэн бөгөөд банкны үйлчилгээний хүртээмж 94% гарсан нь бусад улсуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм.

2.2. Судалгааны аргачлал

Энэхүү судалгааны хүрээнд санхүүгийн хүртээмжийн эрэлтийн талын үзүүлэлтүүдийг тодорхойлж, тэдгээрийг хэмжихэд шаардлагатай тоон өгөгдлийг цуглуулах зорилгоор түүвэр судалгаа хийсэн. Санхүүгийн хүртээмжийн эрэлт талын үзүүлэлтүүд, тэдгээрийн тайлбар болон хэмжигдсэн утгуудыг Хүснэгт 2-оос харах боломжтой. Монгол Улсын хэмжээнд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 500 иргэнээс банк, ББСБ, даатгал (сайн дурын), брокер, дилер, хөрөнгө оруулалтын сан (ХОС), ломбард, болон ХЗХ-ны үйлчилгээний хүртээмж, санхүүгийн боловсрол болон зан төлөвийг үнэлэхэд шаардлагатай асуултууд бүхий асуумжийн дагуу судалгааг авсан.


Санхүүгийн хүртээмжийн асуумжийг боловсруулахдаа гадаадын болон дотоодын баримт бичгүүдэд тулгуурлалаа. Үүнд, Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (The Alliance for Financial Inclusion, AFI)-ийн гаргасан “AFI санхүүгийн хүртээмжийн индикаторуудын үндсэн багц” (2019), “Санхүүгийн хүртээмжийн чанарын индикаторууд” FID удирдамж (2016), “Санхүүгийн зохицуулах хорооны Судалгааны товхимол №2” (2021), болон

“Монгол Улсын санхүүгийн хүртээмжийн түүвэр судалгаа” (2018) зэрэг баримт бичгүүдийг ашигласан.

Түүврийн шинж чанар

Санхүүгийн хүртээмжийн судалгаанд Улаанбаатар хот болон 21 аймгийн нийт 500 иргэн хамрагдсан. Судалгаанд хамрагдсан иргэдийг нас, хүйс, байршил, боловсрол, орлого болон ажил эрхлэлт зэрэг нийгэм, эдийн засгийн шинж чанараар нь ангилж шинжиллээ.

Зураг 1. Бүсийн тархалт



Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Насаар нь 35 түүнээс доош болон 35-аас дээш настай, боловсролоор нь бакалавр түүнээс дээш болон бакалавраас доогуур боловсролтой гэж ангилсан. Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 38.6% нь бакалавр ба түүнээс дээш боловсролтой байна. Иргэдийн амьжиргаатай холбоотой сууцны төрөл болон сарын орлого гэсэн үзүүлэлтүүдийг авч үзсэн. Сууцны төрлийг гэр хороолол ба орон сууц, харин сарын орлогыг 600,000 төгрөгөөс доош бол бага, дээш бол өндөр орлоготой гэж ангиллаа¹. Судалгаанд хамрагдсан иргэдийн 47.3% нь орон сууцанд амьдардаг бөгөөд 22.8% нь орлого багатай байна. Түүнчлэн оролцогчдыг оршин суугаа газраар нь Улаанбаатар ба орон нутаг гэж ялган шинжилгээ хийсэн.

Хүснэгт 1-т түүврийн шинж чанарыг харуулж байна. Нийт оролцогчдын дундаж нас 43.1 бөгөөд 41% нь эрэгтэй, 48.6% нь Улаанбаатарт оршин суудаг, 77.2% нь өндөр орлоготой, талаас илүү нь байнгын орлоготой, 64.5% нь ажилтай байна.

¹ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 660,000 төгрөгтэй уялдуулж энэхүү утгыг сонгосон.

Хүснэгт 1. Түүврийн шинж чанар

	Эзлэх %
Эрэгтэй	41
35 ба түүнээс дээш настай	69.7
Бакалавр ба түүнээс дээш боловсролтой	38.6
Улаанбаатарт амьдардаг	48.6
Гэрлэсэн	76.9
Орон сууцанд амьдардаг	47.3
Өндөр орлоготой	77.2
Байнгын орлоготой	55.5
Ажилтай	64.5

Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Судалгаанд оролцогчдын 38% нь өрхийн тэргүүн, 42.8% нь өрхийн тэргүүний эхнэр эсвэл нөхөр харин 15% нь өрхийн тэргүүнтэй бусад хамааралтай хүмүүс байлаа. Судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь санхүүгийн шийдвэр гаргагчид буюу 61% нь өдөр тутмын санхүүгийн шийдвэрээ өөрөө дангаараа гаргадаг харин 23.2% нь бусадтай хамтарч гаргадаг байна.

2.3. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж

Энэхүү бүлэгт иргэдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмж, санхүүгийн үйлчилгээнд хамрагдах сонирхол болон хамрагдахгүй байгаа шалтгаанд дүн шинжилгээ хийснийг танилцуулж байна. Санхүүгийн хүртээмж, түүнийг хэмжих талаар олон улс болон үндэсний хэмжээнд хийгдсэн судалгаа, тайлан, зөвлөмж зэрэг баримт бичгүүдэд тулгуурлан олон улсад өргөн ашиглагддаг санхүүгийн хүртээмжийн эрэлттэй холбоотой 10 үзүүлэлтүүдийг сонгосон. Санхүүгийн хүртээмжийн эрэлтийн эдгээр үзүүлэлтийн тодорхойлолт болон судалгаанаас үнэлсэн үр дүнг Хүснэгт 2-т нэгтгэн харууллаа. Санхүүгийн хүртээмжийг тухайн санхүүгийн үйлчилгээг хэрэглэдэг иргэдийн нийт иргэдэд эзлэх хувиар хэмжсэн.

Судалгаанд хамрагдсан ихэнх иргэд банкны үйлчилгээг авдаг. Харин банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын үйлчилгээний эрэлт харьцангуй бага байна. Тухайлбал, хэрэглэгчдийн гуравны хоёр нь ББСБ, дөрөвний нэг нь даатгал, тавны нэг нь ломбардын үйлчилгээг авдаг бөгөөд брокер, дилер, ХОС, ХЗХ-оор үйлчлүүлдэг хэрэглэгчид харгалзан 4.4%, 3.6% байна. Иргэдийн санхүүгийн үйлчилгээнд итгэх итгэл болон үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд санхүүгийн байгууллагуудаар ихээхэн ялгаатай байна.

Энэ хэсэгт Монгол Улсын банк, ББСБ, даатгал, хөрөнгийн зах зээл, ХЗХ, Ломбард болон дижитал үйлчилгээний хүртээмжийг иргэдийн нийгэм эдийн засгийн шинж чанартай холбон нарийвчлан шинжилнэ. Санхүүгийн үйлчилгээнд итгэх итгэл, үйлчилгээний чанар, санхүүгийн боловсролыг дараа дараагийн хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

Хүснэгт 2. Санхүүгийн хүртээмжийн эрэлтийн үзүүлэлтүүд

Эрэлтийн үзүүлэлтүүд	Тайлбар	Банк	ББСБ	Даатгал	Брокер, дилер, ХОС	ХЗХ	Ломбард
Санхүүгийн хүртээмж	Санхүүгийн үйлчилгээг авдаг гэж хариулсан иргэдийн %	99%	35.80%	24.40%	4.40%	3.60%	20%
Санхүүгийн үйлчилгээг сонирхож байсан хувь*	Санхүүгийн үйлчилгээг авдаггүй боловч өмнө нь сонирхож байсан гэж хариулсан иргэдийн %			11.50%	4.90%	1.50%	
Санхүүгийн үйлчилгээнд итгэх итгэл	Санхүүгийн үйлчилгээнд итгэдэг болон бага зэрэг итгэдэг гэж хариулсан иргэдийн %	86.60%	53.60%	48.00%	28.60%	24.00%	35.00%
Санхүүгийн үйлчилгээг худалдан авах чадвар*	Санхүүгийн үйлчилгээг авдаг иргэдээс тухайн үйлчилгээний гүйлгээний шимтгэлийг өндөр гэж хариулсан %	73.70%	86.50%	45.50%	31.80%	55.00%	89.00%
Ил тод байдал	Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар тодорхой ойлгомжтой мэдээлэл авсан гэж хариулсан %	83.20%	42.60%	30.60%	9.40%	9.00%	28.20%
Тав тухтай байдал*	Санхүүгийн үйлчилгээг авдаг иргэдээс үйлчилгээг авахад зарцуулдаг хугацаандаа сэтгэл ханамжгүй гэж хариулсан %						
Салбар		5.40%	2.00%	1.10%	0.00%	0.00%	10.00%
Онлайн		0.70%	0.00%	0.00%	0.00%		
Тэгш шударга үйлчилгээ*	Санхүүгийн байгууллагын ажилтан зохисгүй хандсан гэж хариулсан хэрэглэгчдийн %	6.40%	0.40%	0.00%	0.20%	1.40%	0.00%
Зээл авахад учрах бэрхшээл*	Санхүүгийн байгууллагаас зээл аваагүй иргэдээс зээл авахад бэрхшээлтэй учраас аваагүй гэж хариулсан %				5%		
Санхүүгийн боловсролтой иргэдийн %					48%		

Гэнэтийн зүйл тохиолдоход хангалттай хуримтлалтай	Гэнэтийн зүйл тохиолдоход 3-6 сарын амьжиргааны зардлаа санхүүжүүлэх хэмжээний хангалттай хуримтлалтай иргэдийн %	11.60%
--	--	--------

Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов. *Тэмдэглэл:* * Үйлчлүүлсэн хүмүүс эсвэл үйлчлүүлээгүй хүмүүс гэсэн дэд олонлогоос тооцсон хувиуд.

Судалгаанд хамрагдсан иргэд бараг бүхэлдээ (99%) банкны үйлчилгээ авдаг хэдий ч банкнаас бусад байгууллагууд болох ББСБ, даатгал, брокер, дилер, ХОС, ХЗХ болон ломбардын үйлчилгээний хэрэглээ эрс бага байгааг Хүснэгт 3-аас харж болно. Эдгээр байгууллагууд дотроос ББСБ-ын үйлчилгээ авдаг хувь хамгийн өндөр бол ХЗХ-ны үйлчилгээ хамгийн бага байна.

Хүснэгт 3. Санхүүгийн үйлчилгээ авдаг байдал нийгэм, эдийн засгийн шинж чанараар ялгаатай эсэх

	ББСБ	Даатгал	Брокер, дилер, ХОС	ХЗХ	Ломбард
Санхүүгийн үйлчилгээг авдаг хувь	35.8%	24.4%	4.4%	3.6%	20.0%
Бүлгүүдээр статистикийн хувьд ач холбогдолтой эсэх					
Эрэгтэй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм (-)
Улаанбаатарт амьдардаг	Үгүй	Үгүй	Тийм (+)	Үгүй	Тийм (+)
35-аас доош настай	Тийм (+)	Тийм (-)	Үгүй	Үгүй	Үгүй
Гэрлэсэн	Тийм (+)	Тийм (+)	Тийм (+)	Үгүй	Үгүй
Орон сууцанд амьдардаг	Үгүй	Тийм (+)	Тийм (+)	Үгүй	Үгүй
Бакалавр ба дээш боловсролтой	Тийм (+)	Тийм (+)	Тийм (+)	Үгүй	Үгүй
Өндөр орлоготой	Тийм (+)	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Ажилтай	Тийм (+)	Тийм (+)	Үгүй	Үгүй	Үгүй
Байнгын ажлын орлоготой	Тийм (+)	Тийм (+)	Үгүй	Үгүй	Үгүй

Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Тайлбар: Тухайн бүлэг бүрээр хийсэн t-test-ын p-утга 5%-иас бага бол статистикийн хувьд ач холбогдолтой буюу тухайн бүлгээр ялгаатай буюу тийм, p-утга 5%-иас их бол ач холбогдолгүй буюу тухайн бүлгээр ялгаагүй буюу үгүй гэж тэмдэглэв. Ач холбогдолтой үзүүлэлтүүдийн хувьд эерэг сөрөг нөлөөг хаалтад нэмэх хасах тэмдгээр харууллаа.


Брокер, дилер, ХОС болон ХЗХ-ны үйлчилгээний хувьд маш цөөн иргэд хамрагддаг. Иймд эдгээр үйлчилгээг хэрэглэхгүй байгаа шалтгаан болон хэрэглэх сонирхол нь бүлгээр ялгаатай эсэхийг шинжиллээ.

Судалгаанаас ББСБ-ын үйлчилгээг иргэд зээлийн зорилгоор илүүтэй авдаг болох нь ажиглагдлаа. ББСБ-аар үйлчлүүлэгчдийн талаас илүү хувь нь хэрэгтэй үед зээл авч чаддаг учраас уг байгууллагаар үйлчлүүлдэг ажээ. Иймд ББСБ болон ломбардын үйлчилгээний хүртээмжийг банкны үйлчилгээтэй харьцуулах байдлаар шинжилгээг хийлээ. Харин даатгал, брокер, дилер, ХОС болон ХЗХ-ны үйлчилгээний хувьд оролцох сонирхол болон хамрагдахгүй байгаа шалтгаан зэргийг илүү дэлгэрүүлэн шинжилсэн.

2.3.1. ББСБ болон ломбардын үйлчилгээ

Иргэдийн ББСБ-ын үйлчилгээнд хамрагдалт нь нас, гэрлэлт, боловсрол, ажил эрхлэлт болон орлогын түвшин зэргээс хамаарч ялгаатай байдаг бол ломбардын хувьд байршил болон хүйсээс хамаарч ялгаатай байдаг. Зураг 2-т ББСБ болон ломбардын үйлчилгээний хэрэглээг нийгэм, эдийн засгийн тодорхой бүлгүүдээр илүү дэлгэрэнгүй харууллаа.

Зураг 2. ББСБ, ломбардын үйлчилгээний хүртээмж, нийгэм эдийн засгийн шинж чанараар



Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Ломбардаас бусад санхүүгийн үйлчилгээний хүртээмж хүйсээр ялгаагүй. Эмэгтэйчүүд хүү өндөртэй ломбардын үйлчилгээг эрэгтэйчүүдээс илүү авч буй нь анхаарал татаж байна. Эмэгтэйчүүдийн 24% нь ломбардаар үйлчлүүлж байгаа нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад 9 пунктээр илүү байна. Мөн түүнчлэн байршлын хувьд Улаанбаатарт байдаг иргэдийн ломбардын хэрэглээ (28%) байгаа нь орон нутагт амьдардаг иргэдтэй (13%) харьцуулахад 14 пунктээр илүү байна.

Нөгөөтээгүүр банк болон ББСБ гэсэн ломбардтай харьцуулахад хүү багатай Эх сурвалжаас зээл авсан байдалд статистик ач холбогдол бүхий хүйсийн ялгаа байхгүй байна (Хүснэгт 4). Эрэгтэйчүүдийн 25.9%, эмэгтэйчүүдийн 31.9% нь банкнаас зээл авсан бол эрэгтэйчүүдийн 21%, эмэгтэйчүүдийн 20% нь ББСБ-аас зээл авчээ. Энэхүү ялгаа нь статистикийн хувьд ач

холбогдолгүй. Эндээс бид эмэгтэйчүүд бусад төрлийн санхүүгийн байгууллагаас зээл авах боломжгүй учраас ломбардаас илүү их зээл авдаг гэж дүгнэх боломжгүй юм.

Ломбардын үйлчилгээнд эмэгтэйчүүд илүү хамрагддаг нь бусад улсын тоон өгөгдлөөс мөн ажиглагддаг ажээ. 2020 онд Их Британийн ломбард үйлчилгээний хэрэглэгчдийн дунд хийсэн судалгаанд оролцогчдын 67% нь эмэгтэйчүүд байсан бөгөөд энэ нь 2010 онд хийгдсэн хэрэглэгчдийн шинж чанартай ижил байсан гэж судалгаанд дурджээ (Davies, S., & Finney, A, 2020). Эмэгтэйчүүд ломбардаар илүүтэй үйлчлүүлэхэд нөлөөлдөг хүчин зүйлсэд боловсрол, ажил эрхлэлт, санхүүгийн боловсрол болон зан төлөв гэх мэт олон хүчин зүйлсийн нөлөөг хослуулан шинжлэх шаардлагатай.


Ломбард нь банк болон ББСБ-тай харьцуулахад онлайн үйлчилгээ үзүүлэх боломжгүй нь орон нутгийн иргэд бага хамрагдах нэг хүчин зүйл байж болох юм. Мөн түүнчлэн, эзэмшдэг хөрөнгийн төрөл нь орон нутаг болон Улаанбаатар хотод амьдардаг иргэдийн хувьд ялгаатай байдаг нь ломбардад шаарддаг барьцаа хөрөнгийн онцлогтой холбоотой байж болох юм. Үүнийг илүү дэлгэрэнгүй судалгаагаар тодорхойлох боломжтой.

Зураг 2-т харуулснаар 35-аас доош насны иргэд ББСБ-ын үйлчилгээ авах нь 35 ба түүнээс дээш насны иргэдтэй харьцуулахад бараг 10 пунктээр илүү байна. Харин 35 ба түүнээс дээш настай иргэдийн 34.5% нь банкнаас зээл авсан бол 35-аас доош насны иргэдийн 18.5% нь банкнаас зээл авчээ. 35-аас доош насны иргэд эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад банкны зээлийн шалгуурыг хангах магадлал бага байдаг нь ББСБ-д хандахад нөлөөлдөг байж болох юм.

ББСБ-ын үйлчилгээг авдаг 178 хэрэглэгчдийн 51% нь хэрэгтэй үед зээл авч чаддаг учраас, 48.3% нь яаралтай мөнгөний хэрэг гарах үед хандаж болдог шалтгаанаар уг үйлчилгээг авдаг гэсэн байна. Хэрэглэгчдийн ердөө 16.3% нь л төлбөр хийх зорилгоор ББСБ-ын үйлчилгээг хэрэглэдэг гэжээ. Эндээс иргэд үндсэндээ ББСБ-ын үйлчилгээг зээл авах зорилгоор ашигладаг гэж дүгнэж болохоор байна.

Зураг 3-т ББСБ болон ломбардын үйлчилгээний хэрэглээг ажил эрхлэлт, боловсролын түвшин болон орлогын түвшин зэрэг үзүүлэлтээр харуулж байна. ББСБ-ын үйлчилгээний хүртээмж эдгээр шинж чанаруудаар ач холбогдол бүхий ялгаатай байгаа юм. Ажилтай, өндөр орлоготой, боловсролын түвшин өндөр бөгөөд байнгын цалингийн орлоготой иргэд ББСБ-ын үйлчилгээнд илүүтэй хамрагддаг.

Зураг 3. ББСБ, ломбардын үйлчилгээний хэрэглээ, ажил эрхлэлт, боловсрол, орлогын түвшнээр



Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж банк болон банкнаас бусад салбараар эрс ялгаатай байгаад юу нөлөөлж буйг ойлгохын тулд хэрэглэгчдээс тухайн байгууллагаар үйлчлүүлдэг шалтгааныг тандсан бөгөөд энэ нь байгууллагуудаар хэр ялгаатай байгааг шинжилж үзлээ. Судалгаанд хамрагдсан иргэдийн 30.8% нь банкаар үйлчлүүлдэг хоёр, 26.7% нь гурав, 14.8% нь дөрвөн шалтгааныг сонгосон байна. Хамгийн түгээмэл нь мөнгө шилжүүлж, шилжүүлэн авах (83.2%), төлбөр хийх (70%), мөнгөө хадгалахад тусалдаг (44.4%) болон хэрэгтэй үедээ зээл авч чаддаг (32.6%) гэсэн шалтгаанууд ажээ.

2.3.2. Зээлийн үйлчилгээ

Монгол Улс банкны үйлчилгээнд хамрагдалтын үзүүлэлтээр санхүүгийн хүртээмж өндөр хэдий ч банкны зээлийн бүтээгдэхүүний хэрэглээгээр хөгжлийн хувьд ижил түвшний орнуудтай харьцуулахад доогуур байдаг. Санхүүгийн хүртээмжийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн үндэслэлд зээлийн бүтээгдэхүүн өндөр зардалтай байгааг дурдсан байна.

Энэхүү судалгаанд хамрагдсан иргэд бараг бүгд банкны үйлчилгээ авдаг хэдий ч ердөө 30 шахам хувь нь банкнаас зээл авсан байна (Хүснэгт 4). Нөгөөтгээгүүр ердөө гуравны нэг нь ББСБ-ын үйлчилгээ авдаг боловч тавны нэг нь ББСБ-аас зээл авсан байна. Иргэд банкны зээлтэй эсэх нь насны бүлэг болон орлогын түвшнээс бусад шинж чанараар ямар нэг ялгаагүй байхад ББСБ-ын зээлийн хувьд олон шинж чанараар бүлгийн ялгаатай байна.

Хүснэгт 4. Зээл авсан байдал нийгэм, эдийн засгийн шинж чанараар ялгаатай эсэх

	Банкны зээл	ББСБ-ын зээл	Ломбардын зээл
Нийт зээл авсан хувь	29.40%	20.40%	9.20%
Бүлгүүдээр статистикийн хувьд ач холбогдолтой эсэх			
Эрэгтэй	Үгүй	Үгүй	Тийм (-)
Улаанбаатарт амьдардаг	Үгүй	Үгүй	Тийм (+)
35-аас доош настай	Тийм (-)	Үгүй	Үгүй
Гэрлэсэн	Үгүй	Тийм (+)	Үгүй
Орон сууцанд амьдардаг	Үгүй	Үгүй	Үгүй
Бакалавр ба дээш боловсролтой	Үгүй	Тийм (+)	Үгүй
Өндөр орлоготой	Тийм (+)	Тийм (+)	Үгүй
Ажилтай	Үгүй	Тийм (+)	Үгүй
Байнгын ажлын орлоготой	Үгүй	Тийм (+)	Үгүй

Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Тайлбар: Тухайн бүлэг бүрээр хийсэн t-test-ын p-утга 5%-иас бага бол статистикийн хувьд ач холбогдолтой буюу тухайн бүлгээр ялгаатай буюу тийм, p-утга 5%-иас их бол ач холбогдолгүй буюу тухайн бүлгээр ялгаагүй буюу үгүй гэж тэмдэглэв. Ач холбогдолтой үзүүлэлтүүдийн хувьд эерэг сөрөг нөлөөг хаалтад нэмэх хасах тэмдгээр харууллаа.

ББСБ нь банкны үйлчилгээний гадна үлддэг эмзэг бүлгийн бөгөөд орлого багатай иргэдэд хүрч үйлчлэх боломжтой бичил санхүүгийн байгууллага хэдий ч энэхүү судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд орлого өндөр, ажилтай бөгөөд боловсрол өндөртэй нь ББСБ-аар илүүтэй үйлчлүүлж байна.

Судалгаанд оролцогчдын 48.8% нь өнгөрсөн 6 сарын хугацаанд зээл авсан гэж хариулсан бөгөөд давхардсан тоогоор зээл авсан иргэдийн 60.2% нь банкаар, 41.8% нь ББСБ-аар, 18.9% нь ломбардаар, 0.4% нь ХЗХ-оор үйлчлүүлсэн байна. Нийт зээл авсан хэрэглэгчдийн 82.4% нь нэг, 13.9% нь хоёр, 3.7% нь гурван санхүүгийн байгууллагаас зээл авчээ.


Өнгөрсөн зургаан сарын хугацаанд зээл авсан эсэхийг асуухад нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 48.8% нь зээл аваагүй гэжээ. Нийт зээл аваагүй хэрэглэгчдийн 69.7% нь зээл авах шаардлагагүй, 20.6% нь төлж байгаа зээлтэй, 12.2% нь мөнгө зээлэхийг хүсдэггүй эсвэл мөнгө зээлэхэд итгэдэггүй, 5.9% нь өрөө төлж чадахгүй байх гэж санаа зовдог гэсэн бол 5% нь зээл авах нь бэрхшээлтэй учраас гэж хариулжээ.

2.3.3. Даатгалын үйлчилгээ

Энэ судалгаагаар зөвхөн сайн дурын даатгалын үйлчилгээг хамарсан бөгөөд иргэдийн хүсэл сонирхлоос гадна хууль эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай албан журмын даатгалыг хамруулаагүй. Судалгаанд хамрагдсан иргэдийн 24.4% нь сайн дурын даатгалын үйлчилгээнд хамрагдсан бөгөөд хамрагдсан байдал нь хүйс

болон байршлаас бусад шинж чанараараа статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай байна (Хүснэгт 3). Өөрөөр хэлбэл иргэдийн сайн дурын даатгалд хамрагдалт насны бүлэг, гэрлэлтийн статус, сууцны төрөл, боловсролын түвшин, орлогын түвшин болон ажил эрхлэлт зэргээс хамаарч ялгаатай байна (Зураг 4).

Зураг 4. Сайн дурын даатгалд хамрагдалт, нийгэм, эдийн засгийн шинж чанараар



Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Сайн дурын даатгалд байнгын орлоготой, ажилтай, өндөр орлоготой, бакалавр ба түүнээс дээш боловсролтой, гэрлэсэн, орон сууцанд амьдардаг бөгөөд 35 ба түүнээс дээш насны иргэд эсрэг бүлгийнхнээсээ илүүтэй хамрагддаг. Сайн дурын даатгалд хамрагддаг иргэдийн 71.1% нь эрсдэлээс сэргийлэх зорилгоор харин 20.1% нь үйлчилгээ үзүүлсэн болон ажил олгогч гэх мэт байгууллагын шаардлагын дагуу сайн дурын даатгалд хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 79.3% нь энэ хоёр шалтгааны нэгийг харин 20.7% нь хоёуланг нь сонгожээ. Эндээс даатгалд хамрагддаг иргэдийн хувьд эрсдэлээс сэргийлэх буюу өөрийн сонголтоор түгээмэл хэрэглэдэг хэдий ч тодорхой хэсэг нь бусдын шаардлагаар сайн дурын даатгалд хамрагддаг гэж дүгнэж болохоор байна.

2.3.4. Дижитал санхүүгийн үйлчилгээ

Монгол Улсад дижитал санхүүгийн үйлчилгээ нэлээд өргөжсөн бөгөөд дийлэнх хэрэглэгчид нь ямар нэг бэрхшээлгүй хэрэглэдэг байна. Дижитал үйлчилгээний хэрэглээ нь нийгэм эдийн, засгийн зарим шинж чанараар ялгаатай. Тухайлбал, залуу насны, Улаанбаатарт амьдардаг бөгөөд өндөр боловсролтой хүмүүс онлайн үйлчилгээ илүүтэй хэрэглэдэг.

Судалгаанд оролцсон банкаар үйлчлүүлдэг 494 хэрэглэгчдийн 62.9% нь салбар болон онлайннаар хослуулан үйлчлүүлдэг байна. Харин 15% нь зөвхөн салбараар, 22.1% нь зөвхөн онлайннаар үйлчлүүлдэг гэж хариулжээ. Онлайн үйлчилгээ хэрэглэгчдийн 58.9% нь интернэт банк, 52.4% нь мобайл банк ашигладаг бол 21.6% нь аппликэйшний зээл ашигладаг гэжээ. Оролцогчдын 93.6% нь онлайн үйлчилгээ авахад хүндрэл учирч байгаагүй гэж хариулсан бол 6.2% нь тодорхой бэрхшээл тулгарсан гэжээ. Эдгээр бэрхшээл нь ихэвчлэн интернэт гацах, интернэтэд холбогдож чадахгүй байх, эсвэл аппликэйшн алдаа заахтай холбоотой байсан байна.

ББСБ-аар үйлчлүүлдэг 178 үйлчлүүлэгчдийн 27.0% нь салбар болон онлайн аль алианаар нь үйлчлүүлдэг, 27.5% нь зөвхөн салбараар үйлчлүүлдэг бол 43.8% нь зөвхөн онлайннаар үйлчлүүлдэг байна. Судалгаанд оролцогчид monpay, pocket.mn, sono Mongolia зэрэг 23 төрлийн аппликэйшнийг хэрэглэдэг гэж хариулжээ. ББСБ-ын онлайн хэрэглэгчийн 1.6% нь интернэт гацах хүндрэлтэй тулгардаг гэж хариулжээ.

Сайн дурын даатгалын үйлчилгээ авдаг 121 хэрэглэгчийн 66.1% нь зөвхөн салбар дээр очиж үйлчлүүлдэг бол 24.0% нь зөвхөн онлайннаар, 6.6% нь салбар болон онлайннаар үйлчлүүлдэг байна. Брокер, дилер, ХОС-аар үйлчлүүлсэн 22 хэрэглэгчдийн 50% нь зөвхөн онлайннаар, 40.9% нь зөвхөн салбар дээр очиж үйлчлүүлдэг гэж хариулжээ. Эдгээр төрлийн санхүүгийн үйлчилгээг онлайннаар авахад ямар нэг хүндрэл учраагүй гэж хариулжээ.

2.4. Санхүүгийн үйлчилгээг авах сонирхол, итгэх итгэл

ББСБ, ломбард, үнэт цаасны компаниуд (ҮЦК) болон ХЗХ-ны үйлчилгээг сонирхож байсан эсэх, үйлчилгээг авдаггүй шалтгаан болон итгэх итгэл гэсэн үзүүлэлтүүдийг хэмжиж, эдгээр үзүүлэлтүүдэд нийгэм, эдийн шинж чанараас хамааралтай ялгаа байгаа эсэхэд шинжилгээ хийлээ.

Санхүүгийн үйлчилгээнд хамрагдалт банкнаас бусад байгууллагууд, тэр дундаа ҮЦК-иуд болон ХЗХ-ны хувьд эрс бага төдийгүй үйлчлүүлдэггүй хүмүүс дунд сонирхож байсан гэх хариулт маш бага байгаа нь анхаарал татаж байна. Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 95.6% нь брокер, дилер, ХОС-ын үйлчилгээнд хамрагддаггүй бөгөөд эдгээр иргэдийн тав хүрэхгүй хувь нь энэ үйлчилгээг өмнө нь сонирхож байсан гэсэн бол ХЗХ-ны үйлчилгээ

авдаггүй 476 иргэний 1.5% нь уг үйлчилгээг сонирхож байсан байна. Даатгалд хамрагдаагүй 375 иргэний 11.5% нь сайн дурын даатгал сонирхож байсан гэжээ (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Санхүүгийн үйлчилгээг авах сонирхол нийгэм, эдийн засгийн шинж чанараар ялгаатай эсэх

	Сонирхож байсан эсэх		
	Даатгал	Брокер, дилер, ХОС	ХЗХ
Үйлчилгээ авдаггүй иргэдээс үйлчилгээг өмнө нь сонирхож байсан %	11.50%	4.90%	1.50%
Эрэгтэй	Үгүй	Үгүй	Үгүй
Улаанбаатарт амьдардаг	Үгүй	Тийм (+)	Үгүй
35-аас доош настай	Тийм (-)	Үгүй	Үгүй
Гэрлэсэн	Тийм (+)	Үгүй	Тийм (+)
Орон сууцанд амьдардаг	Үгүй	Тийм (+)	Үгүй
Бакалавр ба дээш боловсролтой	Үгүй	Тийм (+)	Үгүй
Өндөр орлоготой	Үгүй	Үгүй	Үгүй
Ажилтай	Тийм (+)	Үгүй	Үгүй
Байнгын ажлын орлоготой	Үгүй	Тийм (+)	Үгүй

Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Тайлбар: Тухайн бүлэг бүрээр хийсэн t-test-ын p-утга 5%-иас бага бол статистикийн хувьд ач холбогдолтой буюу тухайн бүлгээр ялгаатай буюу тийм, p-утга 5%-иас их бол ач холбогдолгүй буюу тухайн бүлгээр ялгаагүй буюу үгүй гэж тэмдэглэв. Ач холбогдолтой үзүүлэлтүүдийн хувьд эерэг сөрөг нөлөөг хаалтад нэмэх хасах тэмдгээр харууллаа.

Сайн дурын даатгалын үйлчилгээ сонирхож байсан хувь нь судалгаанд оролцогчийн нас, гэрлэлтийн статус болон ажил эрхлэлтээс хамаарч ялгаатай байна. 35 ба түүнээс дээш настай иргэдийн 14.7% нь сайн дурын даатгал сонирхож байсан бол залуу бүлгийн хүмүүсийн 5.4% нь ийм даатгал сонирхож байсан байна. Гэрлэсэн хүмүүсийн 14.1% нь даатгал сонирхож байсан нь эсрэг бүлгээсээ 8.1 пунктээр илүү байна. Ажилтай хүмүүсийн 16% нь даатгал сонирхож байсан бол ажилгүй хүмүүсийн хувьд энэ нь гурав дахин бага байна.

ҮЦК-иудын талаар сонирхож байсан эсэхийг асуухад Улаанбаатарт, орон сууцанд амьдардаг, бакалавр ба түүнээс дээш орлоготой бөгөөд байнгын ажлын орлоготой иргэд эсрэг бүлгээсээ илүүтэй сонирхсон гэж хариулжээ.

ББСБ, ломбард, ХЗХ болон ҮЦК-иудын үйлчилгээнд хамрагдахгүй байгаа шалтгааны хамгийн түгээмэл нь хэрэгцээ шаардлагагүй гэсэн хариулт байна. Ийнхүү хэрэгцээ шаардлагагүй гэж үзэж буйд нийгэм, эдийн засгийн шинж чанараар ялгаа байгаа эсэх, мэдлэг мэдээлэлгүй байдал болон эдгээр төрлийн санхүүгийн үйлчилгээнд итгэх итгэл зэрэг нь нөлөөлдөг байж болох юм.

Тухайлсан нэг санхүүгийн үйлчилгээнд хамрагдаагүй хүмүүсээс яагаад хамрагдаагүй шалтгааныг асуухад ББСБ-ын хувьд 40.1%, ломбардын хувьд 67.3%, ХЗХ-ны хувьд 65.1%, ҮЦК-иудын хувьд 53.8%, даатгалын хувьд 63.7% нь тус тус хэрэгцээ шаардлагагүй гэж хариулсан. Энэ хариултыг өгсөн байдалд нийгэм, эдийн засгийн шинж чанараар бүлгийн ялгаа байгаа эсэхийг шинжлэхэд ломбардын хувьд боловсролын түвшний хувьд ялгаатай, даатгалын хувьд сууцны төрөл болон боловсролын түвшнээс статистик ач холбогдол бүхий ялгаа байна.

Боловсрол болон орлогын түвшин өндөр бөгөөд орон сууцанд амьдардаг иргэд эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад даатгал болон ломбардын үйлчилгээг хэрэгцээ, шаардлагагүй гэж илүүтэй хариулсан. Тухайлбал, бакалавр ба түүнээс дээш боловсролтой иргэдийн 66.5% нь ломбардын үйлчилгээ хэрэггүй гэж үзсэн нь эсрэг бүлгээсээ 6 пунктээр илүү бол бакалавр ба дээш боловсролтой иргэдийн 75.7% нь ломбард хэрэггүй гэж үзсэн нь боловсрол доогуур иргэдээс 13 пунктээр илүү байна.

Хүснэгт 6. Санхүүгийн үйлчилгээнд итгэх итгэл нийгэм, эдийн засгийн шинж чанараар ялгаатай

	Банк	ББСБ	Брокер, дилер, ХОС	Даатгал	ХЗХ	Ломбард
Үйлчилгээнд итгэдэг болон бага зэрэг итгэдэг гэсэн %	86.80%	53.60%	28.60%	48%	24%	35%
Мэдэхгүй %	2.60%	16.60%	43.60%	27%	41.40%	20.40%
Итгэдэг хувь нь бүлгүүдээр статистикийн хувьд ач холбогдолтой эсэх						
Эрэгтэй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Улаанбаатарт амьдардаг	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
35-аас доош настай	Үгүй	Үгүй	Тийм (+)	Үгүй	Үгүй	Тийм (+)
Гэрлэсэн	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Орон сууцанд амьдардаг	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм (+)	Үгүй	Үгүй
Бакалавр ба дээш боловсролтой	Үгүй	Тийм (+)	Тийм (+)	Тийм (+)	Үгүй	Үгүй
Өндөр орлоготой	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Ажилтай	Үгүй	Тийм (+)	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Байнгын ажлын орлоготой	Үгүй	Тийм (+)	Тийм (+)	Тийм (+)	Үгүй	Үгүй


Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов. Тайлбар: Тухайн бүлэг бүрээр хийсэн ttest-ын р-утга 5%-иас бага бол статистикийн хувьд ач холбогдолтой буюу тухайн бүлгээр ялгаатай буюу тийм, р-утга 5%-иас их бол ач холбогдолгүй буюу тухайн бүлгээр ялгаагүй буюу үгүй гэж тэмдэглэв. Ач холбогдолтой үзүүлэлтүүдийн хувьд эерэг сөрөг нөлөөг хаалтад нэмэх хасах тэмдгээр харууллаа.

Хэрэглэгчдийн нэлээд хувь нь ББСБ-аас бусад үйлчилгээг хэрэгцээ шаардлагагүй гэж үзэхээс гадна эдгээр үйлчилгээнд итгэх итгэл мөн бага байна. Хүснэгт 6-аас банк болон ББСБ-д иргэдийн талаас илүү хувь нь итгэдэг бол бусад санхүүгийн үйлчилгээнд итгэх итгэл нь нэлээд бага байгааг харж болно. Сайн дурын даатгалд 48% нь итгэдэг гэсэн нь тийм ч бага биш байна. Хүснэгт 6-д мэдэхгүй гэж хариулсан хувийг мөн харууллаа. ХЗХ-д итгэх итгэл хамгийн бага бага байна.

Санхүүгийн үйлчилгээнд итгэх итгэлд хүйс, байршил болон гэрлэлтийн статусаас хамаарсан ялгаа аль ч үйлчилгээний хувьд байхгүй байна. ББСБ, брокер, дилер, ХОС болон даатгалын үйлчилгээнд итгэх итгэл хэд хэдэн бүлгээр ялгаатай байгаа тул тухайн ялгаатай бүлгүүдээр Зураг 5-д харууллаа.

ББСБ, даатгал болон брокер, дилер, ХОС-уудад итгэх итгэл залуу насны, өндөр боловсролтой болон байнгын орлоготой иргэдийн дунд эсрэг бүлгээсээ илүү өндөр байна. Ялангуяа боловсролын түвшин доогуур иргэдийн даатгал болон ҮЦК-иудад итгэх итгэл бага бөгөөд иргэд энэ хоёр үйлчилгээг мэдэхгүй гэж нэлээд их хариулж байгаа нь анхаарал татаж байна. Хөрөнгийн зах зээл болон даатгалын үйлчилгээний мэдээллийг сайжруулж, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах нь эдгээр үйлчилгээнд итгэх итгэлийн нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах нөлөөтэй байж болох юм.

Зураг 5. Санхүүгийн үйлчилгээнд итгэх итгэл нийгэм эдийн засгийн шинж чанараар



Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

2.5. Санхүүгийн үйлчилгээний чанар


Санхүүгийн үйлчилгээний чанарыг хэмжихдээ AFI олон улсын нийгэмлэгээс гаргасан аргачлалын (AFI, 2016) дагуу асуумжийг боловсруулж, хэмжлээ. Уг аргачлалын дагуу санхүүгийн үйлчилгээний чанарыг худалдан авах чадвар, ил тод байдал, тав тухтай байдал, тэгш шударга үйлчилгээ гэсэн үзүүлэлтүүдээр хэмжинэ. Судалгаанд оролцсон хэрэглэгчдийн хариултаас тооцсон эдгээр индикаторуудын утгыг санхүүгийн байгууллагуудаар задалсныг **Error! Reference source not found.**-д үзүүлэв.

AFI олон улсын нийгэмлэгээс гаргасан аргачлалд тодорхойлсон үзүүлэлтүүдийг тухайн улс өөрийн орны онцлогт тохируулан баяжуулан хэрэглэхийг санал болгосон байдаг. СЗХ-ны саналын дагуу үйлчилгээ авахад зарцуулдаг дундаж хугацаанд сэтгэл ханамжгүй үйлчлүүлэгчдийн хувийг гаргахдаа салбар дээр очихоос гадна онлайн үйлчилгээг нэмж оруулсан.

Банк, ББСБ болон ломбардын шимтгэл, хүүг өндөр гэж үздэг хэрэглэгчдийн хувь нэлээд өндөр байна. Банкны үйлчилгээнд бараг бүх иргэд хамрагддаг бөгөөд тэдний гуравны хоёроос илүү нь хүү, шимтгэлийг өндөр гэж үзэж байна. Ил тод байдлын үзүүлэлт банкнаас

бусад санхүүгийн үйлчилгээний хувьд тааруу байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 80 гаруй хувь нь банкны үйлчилгээний талаар ойлгомжтой мэдээлэл авч чаддаг байхад тал хүрэхгүй хувь нь ББСБ болон даатгалын үйлчилгээний талаар ойлгомжтой мэдээлэл авч чаддаг гэжээ. Иргэдийн 10 хүрэхгүй хувь нь ҮЦК болон ХЗХ аль алиных нь талаар тодорхой мэдээлэл авсан гэжээ. Эдгээр байгууллагууд хүртээмжээ сайжруулахын тулд олон нийтэд чиглэсэн мэдлэг, мэдээллийг сайжруулах тал дээр анхаарч ажиллах нь үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлэх нөлөөтэй байж болох юм.

Зураг 6. Санхүүгийн байгууллагууд бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ талаар тодорхой, ойлгомжтой мэдээлэл өгсөн байдал



Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Тав тухтай байдал болон тэгш шударга үйлчилгээний үзүүлэлтүүд нэлээд сайн байна. Мөн түүнчлэн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжгүй байдал онлайн үйлчилгээний хувьд салбартай харьцуулахад эрс бага байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 416 буюу 83.2% нь банкнаас бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ талаар тодорхой ойлгомжтой мэдээлэл авсан гэж хариулжээ (Зураг 6). Бакалавр ба түүнээс дээш боловсролтой иргэдийг бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой иргэдтэй харьцуулахад бүх санхүүгийн байгууллагууд бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ талаар тодорхой, ойлгомжтой мэдээлэл өгсөн гэж хариулах нь өндөр байна. Улаанбаатарт банкнаас бусад бүх байгууллагуудын талаар тодорхой, ойлгомжтой мэдээлэл авах байдал нь илүү байна. 35-аас доош насныхан ХЗХ, брокер, дилер ХОС, ломбард, ББСБ-ын талаар 35-аас дээш насныхантай харьцуулахад илүү тодорхой, ойлгомжтой мэдээлэл авсан гэжээ. Хүйсээр авч үзэхэд, эрэгтэй хүмүүс банк болон ломбардаас бусад санхүүгийн байгууллагын талаар эмэгтэй хүмүүсээс илүү тодорхой, ойлгомжтой мэдээлэл авсан гэжээ.

2.6. Санхүүгийн боловсрол


Санхүүгийн үйлчилгээний эрэлтэд нөлөөлдөг нэг чухал хүчин зүйл нь санхүүгийн боловсрол юм. Санхүүгийн мэдлэг, мэдээлэлтэй хүн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний давуу талыг ойлгож, илүү сайн санхүүгийн шийдвэр гаргадаг бөгөөд санхүүгийн боловсролтой хүн амын эзлэх хувь 1 пунктээр өсөхөд санхүүгийн үйлчилгээний хэрэглээ буюу санхүүгийн хүртээмж 0.5 пунктээр нэмэгддэг байна. (Grohmann et al., 2018), (Grohmann & Menkhoff, 2021).

2014 онд Gallup, Дэлхийн банк, Global Financial Literacy Center байгууллагууд хамтран 143 оронд зохион санхүүгийн боловсролын түүвэр судалгаа зохион байгуулсан бөгөөд уг судалгаанд санхүүгийн боловсролыг эрсдэлийн диверсификаци², инфляц, тоон чадварын нэг нэг асуулт болон хуримтлагдсан хүүгийн талаарх хоёр асуултаар хэмжжээ (Klapper et al., 2015).

Энэ судалгаанд санхүүгийн боловсролыг эрсдэл ба өгөөжийн хамаарал, эрсдэлийн диверсификаци, инфляц, тоон чадварыг шалгах дөрвөн асуултаар хэмжсэн. Эдгээр нь олон улсад санхүүгийн боловсролыг хэмжихэд өргөн ашиглагддаг асуултауд юм(OECD, 2022).

² Диверсификац гэдгийг Эдийн засаг, санхүүгийн тайлбар тольд (<https://toli.mongolbank.mn>) төрөлжүүлэх гэж орчуулсан бөгөөд энэ нь олон төрлийн актив (тухайлбал, хувьцаа, бонд, мөнгөний зах зээлийн хэрэгсэл, эрдэс түүхий эд, хамтын сан)-ыг хөрөнгө оруулалтын нэг багцад багтаах замаар эрсдэлийг бууруулах, нэг төрлийн активаас үүсэж болох эрсдэлийг тархаахыг хэлнэ гэжээ.

Зураг 7. Санхүүгийн боловсролын асуултад зөв хариулсан хувь




Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Монгол Улсын санхүүгийн боловсролын түвшнийг бусад орнуудтай харьцуулах үүднээс Klapper нарын санал болгосон аргачлалаар дөрвөн асуултын багадаа гурвыг нь зөв хариулсан бол санхүүгийн боловсролтой, үгүй бол санхүүгийн боловсролгүй гэж үзсэн (Klapper et al., 2015).

Санхүүгийн хүртээмжийн судалгаанд оролцогчдын бараг тал нь (48.4%) санхүүгийн боловсролтой гэж үнэлэгдсэн. Иргэдийн санхүүгийн боловсролтой холбоотой асуултуудад хариулсан байдлыг Зураг 7 харуулж байна. Оролцогчдын 13.6% нь бүх асуултад зөв, 34.7% нь гурван асуултад зөв хариулжээ. Судалгаанаас үзвэл оролцогчдын 79.6% нь инфляцын тодорхойлолтыг ойлгодог, 63.2% нь эрсдэл ба урамшууллын хоорондын хамаарлыг ойлгодог, 55.4% нь энгийн зээлийн хүүгийн тооцоо хийж чаддаг байна. Гэвч ердөө 36.6% нь л эрсдэлийн диверсификацын талаар мэдлэгтэй байна.

2014 онд Gallup, Дэлхийн банк, Global Financial Literacy Center байгууллагуудын хамтран зохион байгуулсан санхүүгийн боловсролын түүвэр судалгаагаар дэлхийн насанд хүрсэн хүн амын 33.0% нь санхүүгийн боловсролтой байсан бол Монгол Улсын насанд хүрсэн хүн амын 41% нь санхүүгийн боловсролтой байжээ. Харин энэ удаагийн судалгаагаар энэ үзүүлэлт Монгол Улсад 2010-аас 2024 онд 7.3 пунктээр өсжээ.

Зураг 8. Санхүүгийн боловсрол, хүн амын бүлгээр




Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Санхүүгийн боловсрол хүйс, байршлаас хамааралтай боловч орлогоор төдийлөн ялгаатай биш байна (Зураг 8). Эмэгтэйчүүдийн 44% нь санхүүгийн боловсролтой байгаа нь эрэгтэйчүүдийнхээс 10 пунктээр доогуур үзүүлэлт юм. Энэ чиг хандлага дэлхийн бусад орнуудад ч адилхан байна (Klapper et al., 2015). Мөн хот хөдөөгийн ялгаа их байна. Улаанбаатар хотын оролцогчдын 56% нь санхүүгийн боловсролтой бөгөөд хөдөөгийн оролцогчдоос энэ нь 14 пунктээр өндөр байна.

Судалгаанд оролцогчдын 8.4% өөрсдийгөө маш сайн түвшний санхүүгийн боловсролтой гэж үзсэн бол 36.0% нь сайн, 40.2% нь дунд түвшинд байна гэж үнэлжээ. Үүнийг бодит авсан оноотой харьцуулж үзвэл оролцогчдын 32.6% нь өөрсдийн мэдлэгийг бодитой үнэлсэн бол 33.7% нь дутуу, 33.7% нь хэтрүүлэн үнэлсэн байна.

Судалгаанд хамрагдсан оролцогчдын 33.5% нь орлого, зарлагаа хянасан хувийн төсөв сар бүр хөтөлдөг гэж хариулсан. Санхүүгийн боловсрол сайтай оролцогчид төсөв хөтлөх магадлал өндөртэй байна (Зураг 9). Тухайлбал, санхүүгийн боловсролтой иргэдийн 40 гаруй хувь нь төсөв хөтөлж байхад санхүүгийн боловсролгүй иргэдийн 30 хүрэхгүй хувь нь хөтөлдөг байна.

Зураг 9. Санхүүгийн боловсролын оноо ба төсөв хөтлөлт



Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Бид санхүүгийн үйлчилгээнд хамрагддаггүй шалтгаанаа хэрэгцээ шаардлагагүйн улмаас гэсэн хариултыг санхүүгийн боловсролтой холбон шинжилж үзсэн. Иргэд санхүүгийн боловсролтой байхын хирээр санхүүгийн үйлчилгээг хэрэгцээ шаардлагагүй гэж илүүтэй хариулж байна. Брокер, дилер, ХОС-ын үйлчилгээнээс бусад үйлчилгээний хувьд санхүүгийн боловсролтой болон боловсролгүй бүлгүүд хоорондын ялгаа статистик ач холбогдолтой. Тухайлбал, даатгалын үйлчилгээ авдаггүй бөгөөд санхүүгийн боловсролтой иргэдийн 72% нь даатгалын үйлчилгээ хэрэгцээ шаардлагагүй гэж хариулсан нь санхүүгийн боловсролгүй бүлгээсээ 14.7 пунктээр илүү байна. ББСБ, ХЗХ, ломбардын хувьд санхүүгийн боловсролтой иргэдийн 47%, 72%, 76% нь хэрэгцээ шаардлагагүй гэж тус тус хариулсан нь боловсролгүй бүлэгтэйгээ харьцуулахад 13, 12.7, 16.6 пунктээр өндөр байна.

3. ДҮГНЭЛТ

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж банк болон банкнаас бусад салбарын хооронд эрс тэс ялгаатай. Нийт иргэдийн 99% нь банкны үйлчилгээ авдаг бол ББСБ, даатгал, ҮЦК-иуд, ХЗХ болон ломбард зэрэг бусад төрлийн санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлдэг хувь эрс бага байна. Банкнаас бусад салбаруудын хувьд ББСБ-ын үйлчилгээг авдаг хувь хамгийн өндөр бол ХЗХ-ны үйлчилгээ хамгийн бага байна.

Ломбардын үйлчилгээнээс бусад үйлчилгээний хүртээмж хүйсээр ялгаагүй. Хүү өндөртэй зээлийн үйлчилгээнд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүтэй үйлчлүүлж байгаа нь анхаарал татаж байна. Энэхүү ялгаанд юу нөлөөлж байгааг цааш гүнзгийрүүлэн судлах нь сонирхолтой байж болох юм. Олон улсад ч эмэгтэйчүүд ломбардын үйлчилгээг илүү авдаг

байдал ажиглагддаг. Иргэд өдөр тутмын хүнс, хоол гэх мэт зүйлсийн санхүүжилтэд зориулж ломбардын үйлчилгээ авдаг нь мөн Их Британийн ломбардын хэрэглэгчдийн түүвэр судалгаанаас гарчээ.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж нь иргэдийн амьжиргааны түвшин, боловсролын түвшин, нас болон ажил эрхлэлтийн статусаас хамаарсан ялгаа ихтэй байна. Харин хүйс болон байршлаас хамаарсан ялгаа багатай. Орлого багатай, ажилгүй бөгөөд бага боловсролтой иргэдийн банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна. ББСБ-ын үйлчилгээ нь банкны үйлчилгээний гадна үлдэж буй иргэдэд хүрч үйлчлэх боломжтой бичил санхүүгийн салбар гэсэн жишиг олон улсад байдаг. Харин энэхүү судалгаагаар ББСБ-аас илүүтэй ломбардын үйлчилгээнд орлого багатай иргэд хамрагддаг нь ажиглагдлаа. ББСБ-ын үйлчилгээ нь орлого багатай иргэдийг хамруулахаас илүүтэй нийт иргэдийн хурдан, шуурхай зээл авах хэрэгцээг хангахад чиглэдэг ажээ. Банкаар үйлчлүүлэгчдийн дийлэнх нь мөнгө шилжүүлэх, шилжүүлж авах, төлбөр тооцоо хийхийн тулд банкныг ашигладаг гэжээ.

Банкнаас бусад санхүүгийн үйлчилгээнд хамрагдахгүй байгаа хэрэглэгчдийн дийлэнх нь хэрэгцээ шаардлагагүй гэж хариулж байгаа нь анхаарал татаж байна. Ялангуяа, даатгал болон хөрөнгийн зах зээл, ХЗХ-ны үйлчилгээг хэрэгцээ шаардлагагүй учраас авдаггүй гэж үйлчлүүлдэггүй хүмүүсийн талаас илүү хувь нь хариулжээ. Нөгөө талаас энэ төрлийн санхүүгийн үйлчилгээний талаар мэдэхгүй гэсэн хариулт их байна. Мөн түүнчлэн, даатгал, ҮЦК-иуд болон ХЗХ-ны үйлчилгээний талаар тодорхой ойлгомжтой мэдээлэл авсан гэж маш бага хувь нь хариулжээ.

Дижитал санхүүгийн үйлчилгээ нэлээд өргөжсөн бөгөөд дийлэнх хэрэглэгчид нь ямар нэг бэрхшээлгүй хэрэглэдэг байна. Дижитал үйлчилгээний хэрэглээ нь нийгэм эдийн, засгийн зарим шинж чанараар ялгаатай. Тухайлбал, залуу насны, Улаанбаатарт амьдардаг бөгөөд өндөр боловсролтой хүмүүс онлайн үйлчилгээ илүүтэй хэрэглэдэг.

Санхүүгийн үйлчилгээний эрэлтэд нөлөөлдөг нэг чухал хүчин зүйл нь санхүүгийн боловсрол юм. Санхүүгийн мэдлэг, мэдээлэлтэй хүн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний давуу талыг ойлгож, илүү сайн санхүүгийн шийдвэр гаргадаг бөгөөд энэ нь санхүүгийн хүртээмжийг сайжруулдаг. Санхүүгийн хүртээмжийн судалгаанд оролцогчдын бараг тал нь (48.4%) санхүүгийн боловсролтой буюу 1 оноо авчээ. Гэвч ердөө 36.6% нь л эрсдэлийн диверсификацын талаар мэдлэгтэй байна. Монгол Улсын насанд хүрсэн хүн амын санхүүгийн боловсрол 2010-аас 2024 онд 7.3 пунктээр өсжээ.

Санхүүгийн боловсрол хүйс, байршлаас хамааралтай боловч орлогоор төдийлөн ялгаатай биш байна. Эмэгтэйчүүдийн санхүүгийн боловсрол эрэгтэйчүүдийнхээс доогуур байгаа нь дэлхийн бусад орнуудад ч ажиглагддаг хандлага юм (Klapper et al., 2015). Банкнаас бусад санхүүгийн үйлчилгээнд хамрагддаггүй иргэд санхүүгийн боловсролтой байхын хирээр санхүүгийн үйлчилгээг хэрэгцээ шаардлагагүй гэж илүүтэй хариулж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрт санхүүгийн хүртээмжийн тухай энгийн ойлгомжтой тодорхойлолтыг тусгайлан оруулж өгөх.
2. Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн үр дүнг хэмжих үзүүлэлтүүдийн суурь болон зорилтот түвшнийг зорилтот бүлгүүдээр тодорхойлох.
3. Санхүүгийн боловсролыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх явцад тухайн арга хэмжээнээс үүдэлтэй ахиц дэвшлийг үнэлэх арга зүйг нэвтрүүлэх.
4. Дижитал санхүүгийн боловсролыг сайжруулах сургалт, мэдээлэл түгээх арга хэмжээг санхүүгийн хүртээмж сайжруулах хөтөлбөрт тусгайлан оруулж, хэрэгжүүлэх.
5. Санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнг бодитой хэмжихийн тулд санхүүгийн хүртээмжийн эрэлтийн үзүүлэлтүүдийг хэмжих судалгааг 2-3 жил тутамд хийх.
6. Энэ удаагийн судалгаанаас санхүүгийн хүртээмж нь нийгэм, эдийн засгийн шинж чанараар нэлээд ялгаатай байгаа нь ажиглагдлаа. Түүврийн хэмжээ 500 байсан нь бүлгүүдийг интерактив байдлаар хослуулан шинжилгээ хийхэд хангалтгүй байлаа. Иймд дараагийн судалгаануудыг хийхдээ бүлгийн шинжилгээ хийхэд хангалттай байхуйцаар түүврийн хэмжээг урьдчилан тооцоолж тодорхойлох нь зүйтэй.
7. Санхүүгийн хүртээмж, тэр дундаа банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн зарим үзүүлэлтүүдийг ЭН АР СИ СИ судалгааны компанийн Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ)-ын судалгаа, ҮСХ-ны ӨНЭЗС болон аж ахуйн нэгж байгууллагын тооллогын судалгаанаас гаргах боломжтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Sara Davies & Andrea Finney, “*Pawnbroking customers in 2020: a survey of pawnbroking customers*” University of Bristol Personal Finance Study Centre: Bristol, UK, 2020
2. Demirgüç-Kunt, Asli and Klapper, Leora F., “*Measuring Financial Inclusion: The Global Findex Database*”. World Bank Policy Research Working Paper No. 6025, SSRN, 2012, ssrn.com/abstract=2043012, Accessed 15 December 2024
3. Asli Demirgüç-Kunt, Leora Klapper, Dorothe Singer, Saniya Ansar, & Jake Hess, “*The Global Findex Database 2017: Measuring financial inclusion and opportunities to expand access to and use of financial services.*”, The World Bank Economic Review, 2020
4. Antonia Grohmann, Theres Klühs, Lukas Menkhoff, “*Does financial literacy improve financial inclusion? Cross country evidence.*”, World Development, 2018, p.84–96
5. Antonia Grohmann, Lukas Menkhoff. “*The relationship between financial literacy and financial inclusion.*”, The Routledge Handbook of Financial Literacy, Routledge, 2021, p.517-530. Available at: www.taylorfrancis.com/chapters/edit/10.4324/9781003025221-39/relationship-financial-literacy-financial-inclusion-antonia-grohmann-lukas-menkhoff, Accessed 15 December 2024
6. AFI, “*Indicators of the quality dimension of financial inclusion*”, FID Guideline note No.22, Alliance for Financial Inclusion, 2016 (August)

7. Leora Klapper, Annamaria Lusardi, & Peter van Oudheusden, “*Financial Literacy Around the World: Insights from the standard & poor’s ratings services global financial literacy survey*” World Bank. Washington DC: World Bank, 2015, p.218–237.
8. OECD, “*OECD/INFE Toolkit for Measuring Financial Literacy and Financial Inclusion 2022*”, OECD Publishing, Paris, 2022, doi.org/10.1787/cbc4114f-en, Accessed 15 December 2024
9. OECD, “*OECD/INFE 2023 International Survey of Adult Financial Literacy*”, OECD Business and Finance Policy Papers, No. 39, OECD Publishing, Paris, 2023, doi.org/10.1787/56003a32-en, Accessed 15 December 2024
10. Olzii, Peterson K., “*Financial inclusion research around the world: A review*”, Forum for Social Economics, 2021, p.457-479, doi.org/10.1080/07360932.2020.1715238, Accessed 15 December 2024
11. Olzii, Peterson K., Adekemi Ademiju & Semia Rachid, “*Impact of financial inclusion on economic growth: Review of existing literature and directions for future research*”, International Journal of Social Economics, 2023, p.1105-1122, doi.org/10.1108/IJSE-05-2022-0339, Accessed 15 December 2024
12. Venesa Pesqué-Cela, Lihui Tian, Deming Luo, Damian Tobin, Gerhard Kling, “*Defining and measuring financial inclusion: A systematic review and confirmatory factor analysis.*”, Journal of International Development, 2021, Vol.33, Issue.2, p.316-341, doi.org/10.1002/jid.3524, Accessed 15 December 2024
13. World Bank Group, “*Global Financial Inclusion and Consumer Protection Survey, 2017 report*”, World Bank, Washington, DC, 2017, hdl.handle.net/10986/28998, Accessed 15 December 2024